

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурал түүний ажлын хэсэг

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид өөрсдийн соногдсон тойрогт орших сургууль, цэцэрлэгүүдийн 2019-2020 оны хичээлийн шинэ жилийн нээлтэд оролцож, эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж олон жил үр бүтээлтэй ажилласан зарим багш, ажилчдыг аймгийн ИТХ-ын даргын өргөмжлөлөөр шагнаж урамшууллаа.

Төвийн бүсийн аймгуудын ИТХ-ын ажлын албаны ажилтнууд, төвийн сумдын ИТХ-ын дарга нарын туршлага солилцох уулзалт, зөвлөгөөн 09 дүгээр сарын 04-07-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт амжилттай зохион байгуулагдлаа. Энэ удаагийн зөвлөгөөнөөр “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл”, “Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөл”-д санал авах хэлэлцүүлэг зохион байгуулж буйгаараа онцлогтой боллоо.

1996 оны Улсын Их Хурлын тогтоолоор жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдрийг “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр” болгон тэмдэглэж байхаар шийдвэрлэснээс хойш Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссоос өнөөдрийг хүртэл улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах нэр төрийг нь сэргээх, тэдний дурсгалыг мөнхжүүлэх, нөхөх олговор олгох, улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг нийтэд тайлбарлан таниулах ажлыг улс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан тус аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын дарга С.Түмэнбаяр хэлмэгдэгсдийн үр хүүхдүүд, ач зээ нарын нийт 23 төлөөллийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг гардуулан өгч хүндэтгэл үзүүллээ. Мөн орон нутгийн иргэд олон нийтэд хэлмэгдүүлэлтийн тухай баримтат кинонуудыг ДСБ телевизээр дамжуулан хүргэх зэрэг ажлуудыг тус тус зохион байгуулж ажиллалаа.

Энэ оны эхний 9 сарын байдлаар аймгийн салбар комиссоос Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулинд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу нийт 30 гаруй иргэдэд амаар болон утсаар зөвлөгөө өгч одоогийн байдлаар тус аймгаас нөхөн олговор авах 2 иргэний шүүхийн шийдвэр гарч, 7 иргэний нэр “Зууны мэдээ” сонинд зарлагдаж шүүхийн шатандаа явагдаж байна. Тус хуулинд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу нөхөн олговор нь иргэдийн насны дарааллын дагуу өндөр настайгаас эхлэн олгогдож эхлээд байна.

АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 4 ДҮГЭЭР ХУРАЛДААН:

Дорноговь аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл энэ сарын 11-ний өдөр буюу өнөөдөр 76,4 хувийн ирцтэйгээр хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажиллалаа.

Аймгийн Цагдаагийн газраас орон нутгийн хэмжээнд 2019 оны эхний 8 сарын байдлаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, түүний шалтгаан нөхцөлийн талаар мэдээлэл хийж аймгийн ГХУСАЗСЗ-ийн дарга С.Түмэнбаяраас цаашид анхаарах асуудлаар зөвлөлийн нийт гишүүдэд холбогдох үүрэг чиглэлийг өглөө.

Мөн зөвлөлийн хурлаар аймгийн ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажлуудыг зохион байгуулахтай холбоотой зардлуудыг шийдвэрлэв. Үүнд:

- “Хүүхдэд ээлтэй жолооч” арга хэмжээ зохион байгуулах тухай
- Зам тээврийн осол, галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээллийн самбар хийх тухай,
- “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” өдөрлөгт зориулж зардал гаргах
- “Архигүй ирээдүй” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, Хар тамхи мансууруулах бодисоос сэргийлэх нь сэдэвт сургалт зохион байгуулах тухай
- Зарим байгууллагыг камержуулсан тухай мэдээлэл зэргийг хэлэлцэн шийдвэрлэв.

Орон нутгийн хэмжээнд Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгдэж байгаа бөгөөд тус гэмт хэрэг нь гэр орон сууцанд хамгийн ихээр үйлдэгдэж байна. Энэхүү хэрэгт холбогдсон иргэдийн ихэнхи хувь нь ажилгүй залуучууд байгаа бөгөөд иргэдийн стресс бухимдал, архины хэрэглээ их байгаагаас үүдэж энэхүү төрлийн гэмт хэрэг, зөрчил буурахгүй байна гэж үзэж байна. Түүнчлэн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж байгаа бөгөөд үүний шалтгаан нөхцөл нь жолооч нар хувь хүний хариуцлагагүйн улмаас болон замын хөдөлгөөний дүрмээ сайн мэддэггүй, хэт ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас болж ямар ч гэм буруугүй хүмүүс хохирогч нь болж байгаа талаар аймгийн Цагдаагийн газраас мэдээллээ. Үүнтэй уялдуулан зөвлөлийн гишүүдээс босоо тэнхлэгийн авто замын осол гардаг хар цэгүүдэд дэржигнүүр хийх, иргэдийн сонор сэрэмжийг дээшлүүлж анхааруулах тэмдэг тэмдэглэгээнүүдийг хийх санал гаргасныг үр дүнтэй ажил болгож хэрэгжүүлэхээр боллоо.

Түүнчлэн аймгийн ГХУСАЗСЗ-өөс жил бүр нийт сумдад “Иргэдээ сонсьё” өдөрлөгийг зохион байгуулдаг бөгөөд энэ жилийн энэхүү өдөрлөгийг тусгай хуваарийн дагуу 2019 оны 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөөд байна.

“ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЖОЛООЧ” АРГА ХЭМЖЭЭ: Зам тээврийн ослын улмаас улсын хэмжээнд 2019 онд 110 хүүхэд гэмтэж 36 хүүхэд нас барсан байх бөгөөд тус аймгийн хэмжээнд 2019 оны эхний 8 сард мөн 1 хүүхэд нас барж 1 хүүхэд гэмтсэн байна. Үүний шалтгаан нөхцөл нь эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийг автомашинд тээвэрлэхдээ зориулалтын хамгаалалтын суудал, бүс хэрэглэдэггүй, хурд хэтрүүлдэг, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ эсхүл хэт ядарсан үедээ тээврийн

хэрэгсэл жолооддог, эсвэл жолооч нар замын хөдөлгөөний дүрмээ биелүүлдэггүйгээс болж зам тээврийн осол гаргаж түүний хохирогч нь хүүхдүүд болдог. Иймд эцэг, эхчүүд, эрхэм жолоочид, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг хүүхдийн аюулгүй байдал, хүүхдэд ээлтэй нийгмийн төлөө үүргээ ухамсарлан нэгдэж, жолооч нарыг замын хөдөлгөөнд соёлтой оролцуулах зорилгоор аймгийн ГХУСАЗСЗ-өөс Автотээврийн төв, Сайншанд сумын ЗДТГ-тай хамтран “Хүүхдэд ээлтэй жолооч” арга хэмжээг 09 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Арга хэмжээнд нийтийн тээвэр, такси үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын нийт 40 гаруй төлөөлөл оролцов.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн дарга С.Түмэнбаяр арга хэмжээнд оролцож орон нутгийн телевизээр дамжуулан “Орон нутагт нийтийн тээврийн үүрэг гүйцэтгэж яваа жолооч нарт дараах уриалгыг гаргасан. Үүнд:

- Хүүхдийг хүрэх ёстой гэр, сургуульд нь заавал хүргэж өгөх
 - Хүүхдэд ээлтэй байж цаг агаарын таагүй үед болон чиглэл өөр гээд такси авахгүй байгаа үед анхаарч тусалж хүргэж өгч байх
 - Хүүхдэд ээлтэй жолооч болохынхоо хувьд хүүхдийг аюулгүй тээвэрлэхэд онцгой анхаарч, замын хөдөлгөөний дүрэм журмаа үлгэр жишээч баримтлах
 - Хүүхдийг үйлчлүүлэгч гэж үзэж тэдэнтэй зүй ёсоор хүндэтгэж харилцах
- Хүүхдээс зохих тогтсон тарифаар нь үйлчилгээнийхээ хөлсийг авах
“Хүүхдэд ээлтэй жолооч” машинд тавих 100 ширхэг тэмдгийг /дугаар бүхий тавиур/ жолооч нарт тарааж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгууллаа.

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 11 ДҮГЭЭР ХУРАЛ:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 11 дүгээр хурлыг 09 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Тус хурлын ирц 54,5%, Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцлээ. Үүнд:

- Нэрэмжит болгох тухай
- Хөвсгөл сумын "Хутаг уул"-ыг Төрийн тахилгатай болгох асуудлыг уламжлах тухай
- "Төлөөлөгчийн өдөрлөг" зохион байгуулах тухай
- Монгол Улсын төрийн дээд шагналд уламжлах тухай

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ 70 ЖИЛИЙН ОЙН БАЯР: Монгол Улс-БНХАУ-ын хувьд түүхэн ач холбогдол бүхий жил бөгөөд Монгол Улс шинэ Хятад улстай дипломат харилцаа тогтоосон анхны орнуудын нэг болж ийнхүү БНХАУ, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жил, Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээг шинэчилсний 25 жилийн ой тохиож 09 дүгээр сарын 24-ний өдөр Дорноговь аймаг, БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа ерөнхий консулын газар хамтран Монгол-Хятад улс дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд зориулсан баярын хурлыг “Саран хөхөө” театрт ёслол төгөлдөр зохион байгуулсан.

Тус баярын хуралд аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа ерөнхий консул Цай Веньруй, аймгийн Засаг даргын орлогч Г.Эрдэнэцэцэг, аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга Н.Хонгорзул нар оролцож ойн баярын мэндчилгээ дэвшүүлэн, баяр хүргэлээ.

Орон нутгийн иргэдэд төрийн бодлого шийдвэрийг сурталчлан таниулах, үйлчилгээ үзүүлэх, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч холбогдох шийдвэр гаргах, аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн тойрогтоо ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Төлөөлөгчийн болон Иргэдээ сонсьё өдөрлөг” нэгдсэн арга хэмжээг 2019 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн сумдад зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Үүнтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Н.Хонгорзул тус арга хэмжээний зохион байгуулалтыг хэрхэн хийх талаар сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нартай ажил хэргийн уулзалт зохион байгуулав.

Аймгийн ИТХ-аас жил бүр зохион байгуулдаг энэхүү өдөрлөгийн үеэр иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, аймгийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчдөөс хийсэн ажлаа иргэдэд тайлагнах, мэдээлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд мэдээлэл өгөх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, тухайн сумын ИТХ-аас зохион байгуулах ажил зэрэг хөтөлбөрт ажлууд хийгдэх юм.

Аймгийн итх-ын даргын өргөмжлөл: 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Аймгийн ИТХ-ын даргын “Өргөмжлөл”-өөр нийт 14 иргэн

Аймгийн итх-ын даргын захирамж: 09-р сард нийт аймгийн ИТХ-ын даргын 9 захирамж гарсанаас ангилахад Шагнах тухай-2, Хөрөнгө зарцуулах тухай-2, Дэмжлэг үзүүлэх-3, Хүндэтгэл үзүүлэх тухай-1, Буцалтгүй тусламж үзүүлэх тухай-1 тус тус болно.

Албан бичиг, өргөдөл: Аймгийн ИТХ-ын ажлын албанд нийт 54 албан бичиг ирж, ажлын албанаас нийт албан бичиг гадагшаа 28 байгууллагуудруу явсан болно. Иргэдээс аймгийн ИТХ-д нийт 2 өргөдөл ирүүлснийг бүрэн шийдэрлэсэн болно.

2. Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар

2.1. Төрийн захиргааны удирдлагын чиглэлээр: Монгол улсын Төрийн албаны зөвлөлөөс Төрийн албаны шинэтгэлийг сурталчлан таниулах зорилгоор Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайханаар ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 09 сарын 21-24-ний өдрүүдэд Дорноговь аймагт ажиллаж Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан дагалдан гарсан дүрэм, журмыг танилцуулах, Төрийн албаны зөвлөлөөс “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор аймгийн төрийн захиргааны болон нутгийн захиргааны 300 орчим албан хаагчдад сургалт зохион байгууллаа.

Мөн дээрх ажлын хэсэг нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настнуудтай уулзаж, тэдний санал хүсэлт, сургамж зөвлөгөөг сонсож, төрийн албаны шинэтгэлийн талаар ярилцсан.

Ажиллах хугацаандаа аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын харьяаны агентлаг, Айраг, Замын-Үүд сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаатай танилцаж, бүтэц, орон тоо, албан тушаалын

томилгоотой холбогдох шийдвэрийг судлан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2019 оны А/551 дүгээр захирамжаар сумдын төрийн жинхэнэ албан хаагчдыг 2019 оны 09 дүгээр сарын 16-аас эхлэн сэлгэн ажиллууллаа. Төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, ажлын дадлага олгож туршлага судлуулах, ажлын байран дээр суралцуулах зорилго бүхий энэхүү үйл ажиллагаанд нийт 29 төрийн албан хаагчид хамрагдан сэлгэн ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулж зөвлөлийн ажиллах журмыг Төрийн албаны салбар зөвлөлийн тогтоолоор батлуулан ажиллаж байна.

Төрийн албаны ерөнхий шалгалт зарлагдсантай холбогдуулан уг шалгалтыг орон нутагт зохион байгуулах салбар комиссыг байгуулж бэлтгэл ажлаа хангаж байна.

Онцгой байдлын ерөнхий газраас АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Энэтхэг, Номхон далайн цэргийн командлалтай хамтран Дорноговь аймагт зохион байгуулж байгаа “Говийн чоно-2019” гамшгийн хор уршгийг арилгах олон улсын сургалт, дадлага сургуулийг 09 дүгээр сарын 09-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан.

Дадлага сургуульд Монгол, АНУ-аас гадна Австрали, Канад, Франц, Нипаль, Турк, Их Британи, Бангладеш, Индонези, Казахстан, Киргизстан, Лаос, Балба, Шри-Ланка, Тайланд, Тажикистан, Вьетнам зэрэг 21 улс орон, НҮБ-ын төрөлжсөн агентлагийн төлөөлөл болон гамшгийн эрсдэлийн бууруулах чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагууд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, ЭМЯ, БХБЯ, ХХААХҮЯ, ЗХЖШ, МЭЕГ, ЦЕГ, МХЕГ, Улаанбаатар төмөр зам, Автотээврийн үндэсний төв болоод Өмнөд Бүсийн төв Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр, Зүүн бүсийн төв Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудын Онцгой комисс, Онцгой байдлын газрууд, ОБЕГ-ын Үндэсний аврах бригад, Нийслэлийн Онцгой байдлын газар, ДХИС-ийн Онцгой байдлын сургууль, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын нийт 460 гаруй төлөөлөл оролцсон.

“Говийн чоно 2019” гамшгийн хор уршгийг арилгах олон улсын сургалт, дадлага сургууль нь “Орон нутгийн чадавх ба бүс нутгийн харилцан ажиллагаа” сэдвийн хүрээнд танхимын, академик болон болзошгүй гамшгийн хор уршгийг арилгах дууриалган үзүүлэх дадлага сургууль болоод орон нутгийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг турших, гамшиг, аюулт үзэгдэл ослын бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах удирдах бүрэлдэхүүний команд штабын сургууль гэсэн 4 чиглэлээр 21 төрлийн сургалт зохион байгуулагдаж, мэргэжлийн анги байгууллагуудын алба хаагчдыг чадавхжуулаад байна.

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт хандаж иргэдээс 33 өргөдөл, гомдол ирүүлснээс 29 өргөдлийг нь хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн бөгөөд хугацаа болоогүй судлагдах шатандаа 4 өргөдөл байна.

Аймгийн Засаг дарга 9-р сард нийт 25 иргэнийг өөрийн биеэр хүлээн авч, уулзан санал хүсэлтийг шийдвэрлэн ажилласан.

Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар ирүүлсэн 26 иргэний материалыг хүлээн авч хянан үзээд 19 иргэний материалыг холбогдох дээд байгууллагын саналыг авч аймгийн ИТХ-д хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулах тухай нийт 89 материал хүлээн авч хянан үзээд аймгийн Засаг даргын Жуух бичгээр 32, өргөмжлөлөөр 48 хүнийг шагнаж урамшуулсан.

Гадаад харилцааны чиглэлээр: Дорноговь аймаг, БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газраас хамтран Монгол-Хятад улсын дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд зориулсан баярын хурал 2019 оны 09-р сарын 24-ны өдөр болж, баярын хуралд аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консул Цай Вень Руй, аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга Н.Хонгорзул болон албаны төлөөллүүд, ЕБС-ын сурагчид болон АШУИС-ын Дорноговь салбар сургуулийн оюутнууд оролцлоо.

БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газраас АШУИС-ын Дорноговь салбар сургуульд суралцаж буй 15 оюутанд тус бүр 1 сая төгрөгийн сургалтын тэтгэлэг, ЕБС-ын зорилтод бүлгийн 67 сурагчид тус бүр 300 мянган төгрөгийн тэтгэмж гардууллаа.

Мөн Хятад Монгол улс дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойг тохиолдуулан БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газраас зохион байгуулсан “Миний мэдэх Хятад, Монголын харилцаа” сэдэвт гар зургийн уралдаан, “Миний мэдэх Хятад улс” сэдэвт зохион бичлэгийн уралдааны шилдгүүдийн шагналыг гардууллаа. Дорноговь аймаг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хот хоорондын хамтын ажиллагаа болон “Нэг бүс ба нэг зам” санаачилгын “Гэрэлт зам” аяны хүрээнд Дорноговь аймгийн нүдний болор цайх эмгэгтэй 49 иргэнийг нүдний болор суулгах мэс засалд үнэ төлбөргүй хамрууллаа. Мэс заслыг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод Хөх хотын Эрүүл мэндийн Шинжлэх ухааны сургуулийн харьяа эмнэлгийн Нүдний эмч нар Герман улсын орчин үеийн тоног төхөөрөмжөөр хийсэн.

“Гэрэлт зам” аяны хүрээнд 2017 онд 10, 2018 онд 7 иргэнд нүдний болор суулгах мэс засалд үнэ төлбөргүй амжилттай хамрагдсан бөгөөд 2021 он хүртэл Монгол улсаас нийт 500 иргэн нүдний болор суулгах мэс засалд хамрагдах боломжтой тул нүдний энэ төрлийн эмгэгтэй иргэд аймгийн Нэгдсэн эмнэлгийн нүдний эмчийн хяналтад оруулж бүртгэж байгаа юм.

“Гэрэлт зам” аяны албан ёсны үйл ажиллагаа 2019 оны 09-р сарын 26-ны өдөр Эрээн хотод болж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны дарга Бү Сяо Лин, Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, ӨМӨЗО-ны Улаан загалмайн нийгэмлэгийн орлогч дарга Ван Ван нар оролцож албан ёсны нээлтийн үг хэллээ.

2.2. Хууль эрхзүйн чиглэлээр: “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үүрэг оролцоо” сэдвийн хүрээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Хууль сахиулах үүргийн байгууллагуудын

хамтарсан 3 дугаар улирлын хэлэлцүүлгийг зохион байгуулж Айраг, Даланжаргалан сумын Засаг даргын болон бусад холбогдох газрын мэдээлийг сонсон хэлэлцүүлгийг зохион байгуулав.

Аймгийн ЗДТГ-ын даргын баталсан Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагууд, сумдын Засаг даргын Тамгын газар, төсвийн байгууллагуудын 2019 оны цахим хуудасны мэдээллийн ил тод байдалд хяналт шинжилгээ хийх удирдамжийн дагуу Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэстэй хамтран 26 байгууллага, 14 сумын Засаг даргын Тамгын газар, 82 төсвийн байгууллагын цахим сангийн ашиглалтад хяналт шинжилгээ хийлээ.

Хууль зүйн туслалцааны төвийн салбар зөвлөлийн өмгөөлөгч Т.Урангоо тайлант хугацаанд 7 сэжигтэн, яллагдагчид хамаарсан 2 хүнд, 5 хөнгөн эрүүгийн хэргийн нийт 7 яллагдагчийн эрх ашгийг хамгаалахаар оролцсон байна.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны талаар: Эцэг, эхчүүд, эрхэм жолоочид, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг хүүхдийн аюулгүй байдал, хүүхдэд ээлтэй нийгмийн төлөө үүргээ ухамсарлан нэгдэж, жолооч нарыг замын хөдөлгөөнд соёлтой оролцуулах зорилгоор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон төрийн байгууллагууд хамтран “Хүүхдэд ээлтэй жолооч” арга хэмжээг 2019 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Арга хэмжээнд нийтийн тээвэр, такси үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын нийт 40 гаруй төлөөлөл оролцлоо.

Мөн тайлант хугацаанд “Хичээлийн шинэ жил”, “Мотоцикль” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж холбогдох олон талт арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.

Галт зэвсгийн тухай хууль, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2015 оны А/220 дугаар тушаалаар батлагдсан “Галт зэвсгийн тооллого явуулах” журамд заасны дагуу иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа галт зэвсгийн тооллогыг 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 20 хүртэл хугацаанд галт зэвсгийг бүртгэх, гэрчилгээжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж байна.

Аймгийн Цагдаагийн газар “Шилдэг хэсгийн төлөөлөгч-2019” ажил мэргэжил, ур чадварын уралдааныг зохион байгуулж, 15 хэсгийн төлөөлөгч мэдлэг, ур чадвараа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байранд Даланжаргалан сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Б.Гандаваа, дэд байранд Иххэт сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Бат-Эрдэнэ, гутгаар байранд эрүүгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Б.Энхмөрөн нар шалгарсан.

Улсын бүртгэлийн ажлын чиглэлээр: Иргэний Улсын бүртгэлийн чиглэлээр нийт 3362 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласан. Үүнд:

- Төрсний бүртгэл – 152
- Гэрлэлтийн бүртгэл – 53
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл - 7
- Үрчлэлтийн бүртгэл – 2

- Эцэг тогтоосны бүртгэл – 22
- Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 9
- Нас баралтын бүртгэл – 40
- Нийт олгосон иргэний үнэмлэх – 421
- Шилжилт хөдөлгөөний бзртгэл – 965
- Гадаад паспорт, нэг болон олон удаагийн хавсралт – 1407
- Лавлагаа - 283

Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 637 мэдүүлгийг хүлээн авч EPRS программд бүртгэл хийлээ. Үүнд:

- Газраас бусад эд хөрөнгийн анхны бүртгэл – 20
- Шинээр баригдсан орон сууц – 1
- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 97
- Өмчлөх эрх шилжих гэрээ – 14
- Барьцааны гэрээ – 299
- Лавлагаа – 27

Эдгээр бүртгэлийг хийснээр үйлчилгээний хураамжинд 5129775 төгрөгийг, тэмдэгтийн хураамжинд 85100 төгрөгийг, үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого 90290000 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. Мөн Сайншанд сумын 3 болон 4 дүгээр багт баригдаж буй орон сууцанд орох хүсэлтэй 300 гаруй иргэдийн мэдээллийг тойрох хуудсны дагуу шүүж баталгаажуулж ажилласан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 53 бүртгэл хийсэн байна. Үүнд:

- Шинээр бүртгүүлсэн хуулийн этгээд – 16
- Мэдээлэлдээ өөрчлөлт оруулсан – 15
- Тамга тэмдгийн хяналтын дугаар олгосон - 21
- Хориг цуцалсан – 1

Хуулийн этгээдийн бүртгэлээс орон нутгийн төсөвт 7478500 төгрөгийг, улсын төсөвт 114000 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Архив албан хэрэг хөтлөлтийн талаар: “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийн нэгдсэн дүнг аймгийн Засаг даргын өргөтгөсөн хурал дээр танилцуулж, цаашид анхаарах асуудлаар агентлаг тус бүрт үүрэг чиглэл өгсөн.

Аймгийн Архивын тасагт 90 иргэн, 3 байгууллагаас өргөдөл, хүсэлт ирүүлснийг хүлээн авч, 52 архивын лавлагаа, тодорхойлолт олгож, 72 иргэнд 100 архивын баримтын хуулбар олгож үйлчилсэн. Сум дундын иргэний анхан шатны шүүхэд 3 иргэнд холбогдох нотлох баримт, 1 байгууллагад зураг төслийн баримтын хуулбар олгосон.

Замын-Үүд дэх Гаалийн газар, Чандмань бадрал ХХК, Сайншанд сумын ЕБ-ын 3 дугаар сургуулийн архив, бичиг архив, бичиг хэргийн ажилтныг хүлээн авч 2019 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, Устгах хэргийн актыг хянаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Архивын тасгийн цахимжуулалтын ажлын төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн газар, Холбооны газрын 1969-1997 оны 39 хадгаламжийн нэгжийн 4912 хуудас захирамжлалын баримт бичиг программд шивж, цахим мэдээллийн сан үүсгэв. Аймгийн ЗДТГ-ын 2000-2002, Холбооны газрын 1990-1997 оны 20 хн-ийн 4714 хуудас баримтыг фотошоп программын тусламжтайгаар засвараж ашиглалтын хувь үйлдэв.

Замын-Үүд, Сайхандулаан сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт заавар зөвлөгөө өгч, хурлын баримт бичгийг скайнердуулж, фотошоп программаар засварлуулах ажлыг гүйцэтгүүлж байна.

Төрийн архивын сан хөмрөгийн 2019 оны нөхөн бүрдүүлэлтийн ажлын графикийн дагуу Сайншанд сумын ЗДТГ-аас 134 байнга хадгалах хадгаламжийн нэгж хүлээн авч, хамгаалалтын хайрцагт хийж байрлуулсан.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/871 дүгээр захирамжаар байгуулагдсан “Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс”-ын бүрэлдэхүүнд 8 удаа ажиллаж, 4 объектийн зураг төслийн баримт бичгийг зохих зааврын дагуу цэгцлүүлж хүлээн авч, акт үйлдэв.

Аймаг, сумдын 11 байгууллагаас хэвлэмэл хуудасны захиалгыг хүлээн авч, Нийтлэг үйлчилгээний газарт хүргүүлэн, 9 байгууллагын 13 төрлийн хэвлэмэл хуудасны эхийг хянаж, 3820 хуудас хэвлэх зөвшөөрөл олгов.

2.3. Санхүү, төрийн сангийн чиглэлээр: Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 37 төсөвт байгууллагын данс, 37 нэмэлт төсвийн данс, 25 сангийн данс нийт 99 дансны 8,2 тэр бум төгрөгний зарлагын гүйлгээг програмд шивэж төв төрийн санд дамжуулж, төлбөрийн баримтын архивын нэгж үүсгэн ажиллаж байна.

Нэмэлт болон ахмадын сангийн санхүүжилтийн эрхийг нээхдээ Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 73 тушаалыг үндэслэн баримтын бүрдлийг хянаж нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээж, эрх нээсэн баримтыг архивын нэгж үүсгэн ажиллаж байна.

Сумдын төрийн сангийн өдөр тутмын гүйлгээнд e-report системээр хяналт тавьж, нийт 14 сумын 52 алдаа зөрчлийг залруулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,4 тэр бум, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 485 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 446 сая төгрөгийн санхүүжилтийг холбогдох бичиг баримтыг үндэслэн санхүүжүүлсэн. Сумдын орон нутгийн хөгжлийн санд нийт 9 суманд 245 сая төгрөгийн санхүүжилтийн нээсэн. 2 аж ахуйн нэгжийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хүсэлтийн дагуу залруулга хийн мөн 3 аж ахуйн нэгжийг шинээр бүртгэж заавар зөвөлгөө өгч ажилласан

Санхүүгийн хяналт, аудитын алба: Аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Албаны даргын баталсан 12 тоот удирдамжаар Замын-Үүд сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль, сумын Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, Орон нутгийн хөгжлийн сан, Хөрөнгө оруулалт, Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг зэрэг байгууллагуудын 2017-2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Орон нутгийн өмчийн газар:

- Худалдан авах ажиллагааны хүрээнд: Дорноговь аймгийн Худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2019 оны 09 дүгээр сард цахим

системээр /tender.gov.mn/ 6 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээ байгуулж эрх олгосон 1 төсөл арга хэмжээ, шууд гэрээ байгуулсан 4 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үр дүнг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэн ажилласан. Зохион байгуулагдсан төсөл арга хэмжээний тендерийн урилга, тендер шалгаруулалтын явцад гарсан үр дүнг тухай бүрд нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn, www.dornogovi.gov.mn цахим хуудаст байршуулж, нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг тендер зарлагдсан өдөрт нь өдөр тутмын “Монголын мэдээ” сонинд нийтлүүлсэн. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл 98 хувьтай байна. 09 дүгээр сард Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль болон бусад хууль эрх зүйн актуудын хэрэгжилтийн байдалтай танилцах аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэл орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд шалгалт хийж тулгарч буй асуудлыг дүгнэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг засаж сайжруулах чиглэлээр Сангийн яамны шалгалтад худалдан авах ажиллагааны 2018 оны тендер шалгаруулалтын баримт бичгийг шалгуулсан.

- Орон нутгийн өмчийн хүрээнд: Орон нутгийн өмчит 25 хуулийн этгээдийн иргэдтэй байгуулсан эд хөрөнгийн түрээсийн гэрээг хянаж баталгаажуулан орлого төвлөрүүлэлтэнд хяналт тавин 3 дугаар улирлын байдлаар 26,3 сая төгрөгийг төвлөрүүлээд байна. Түрээсийн орлогын төлөвлөгөө 87,6 хувийн биелэлттэй ажиллаж байна. 2019 онд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт бусад эх үүсвэрээр бэлтгэгдсэн хөрөнгүүдийг байгууллагын данс бүртгэлд цаг тухай бүрт нь бүртгэлжүүлэн ажиллаж байгаад хяналтийг хийж байна. Аймгийн Засаг даргын баталсан удирдамжын дагуу Сайншанд сумын ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдийн үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалтыг 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 18-ны өдрийг дуустал хийж байна.

Бусад: Манай газарт ирүүлсэн албан бичгийг цаг тухай бүрт нь шийдвэрлэн хариуг хүргүүлэн ажиллаж байна. Мөн Худалдан авах ажиллагааны баримт материалыг архивлах ажил хийгдэж байна.

Татварын хэлтэс: Улс ба орон нутгийн төсөвт 676412,2 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлэн ажилласан. Тайланг хугацаанд 32 татвар төлөгчөөс 9 төрлийн тайланг хүлээн авч ажилласан. 280 татвар төлөгчдөд Татварын хууль, НӨАТ-ын урамшууллын системээр зөвлөгөө зааварчилгаа өгч ажиллалаа.

Аймгийн Улсын бүртгэлээс шинээр үүсэн байгуулагдсан 3, нэмэлт өөрчлөлт хийгдсэн 2 хуулийн этгээдийн мэдээллийг баазад бүртгэж ажиллалаа.

Татварын ерөнхий газрын даргын баталсан 2019 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу 2 татвар төлөгчийг татварын хяналт шалгалтанд хамруулж байна.

Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх, нуугдмал орлогын эх үүсвэрийг бий болгох ажлын хүрээнд 3 байгууллагаас 1420,3 сая төгрөгийн 5 мэдээллийг цуглуулж нэгтгэн тасгуудыг мэдээллээр ханган ажиллалаа.

Статистикийн хэлтэс: Сар бүрийн хөдөө аж ахуйн мэдээ тайлан, аж үйлдэрийн салбарын мэдээ, 238 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг аймгийн төвөөс, 142 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийг 5 сумдаас авч мөн улирал тутамд барилга, зочид

буудал, зоогийн газар, худалдаа, тээвэр, холбооны салбарын мэдээ тайланг аж ахуй нэгж, иргэдээс цуглуулан авч, нягтлан шалгаж программд шивж дамжууллаа.

2019 оны 9-р сард Ажиллах хүчний судалгаа, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаанд Сайншанд, Дэлгэрэх, Айраг, Иххэт, Хатанбулаг, Хөвсгөл сумдын нийт 76 өрхөөс судалгааг авч, Үндэсний Статистикийн хороонд дамжуулах бэлтгэл ажил хийгдэж байна.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2019 оны 8-р сарын танилцуулга болон илтгэлийг бэлтгэж цахимаар хэрэглэгчдэд тархааж, мөн facebook болон цахим хуудсанд байршуулсан.

Дорноговь аймагт байшин орон сууцны тооллого 2019 оны 09-р сарын 24-ний өдрөөс 2019 оны 10-р сарын 12-ны өдрүүдэд явагдана. Тооллого нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа бүх байшин, орон сууцны сан хөмрөгийг бүрэн тодорхойлох, орон сууцны фонд, хийц, ашиглалт, хүчин чадал, дэд бүтцийн хүртээмжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийн сантай болох, Монгол Улсын сууцны суурь мэдээллийг Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн хамгийн бага нэгжийн түвшинд гаргах, төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрийн төлөвлөлт болоод олон улсад гаргаж буй хөгжлийн үзүүлэлтүүдийн суурь мэдээллийг бий болгох зорилготой.

Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд сургагч багш бэлтгэх сургалт Дундговь аймгийн төвд 09-р сарын 14-нөөс 16-ны хооронд зохион байгуулагдах сургалтанд тус хэлтсийн 6 албан хаагч хамрагдав.

Байшин, орон сууцны тооллогын тоологч нарын сургалтыг Сайншанд суманд 09-р сарын 19-нөөс 20-ны хооронд зохион байгуулав. Сургалтанд аймаг, сумдын 30 тоологч хамрагдав.

Мөн сумдын Хүн ам, орон сууцны тооллогын түр товчоо, багийн түр товчооны гишүүдэд онлайн сургалтыг 09-р сарын 20-ны өдөр зохион байгуулав.

Байшин, орон сууцны тооллогын талаар орон нутгийн DTV телевизэд хэлтсийн дарга Х.Өлзийсүрэн мэдээлэл хийлээ.

Аймгийн түр товчооны хурлыг 2019 оны 09-р сарын 25-ны өдөр зохион байгуулаа. Хурлаар Хүн ам орон сууцны 2020 оны тооллого болон Байшин орон сууцны 2019 оны тооллогыг зохион байгуулж явуулах эрх зүйн үндэслэл, зорилго, удирдлага зохион байгуулалт, мэдээлэл цуглуулах арга, хэлбэр, хамрах хүрээний талаархи дэлгэрэнгүй мэдээллийг аймгийн тооллогын түр товчооны гишүүдэд хүргэж санал солилцлоо. Мөн тооллогын явцын мэдээг тоологчоос суманд, сумаас аймгийн түр товчоонд хэрхэн мэдээлэх, шалгах, Үндэсний статистикийн хороонд дамжуулах талаар мэдээлэл өглөө. Байшин орон сууцны тооллогод ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарь болон сумдад хяналтаар ажиллах хуваарийг гишүүдэд хүргүүлэв.

Улаанбаатар хотноо 09-р сарын 19-20-ны өдөр болж буй Бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтны улсын зөвлөгөөнд хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Цэрэндорж хамрагдаж байна.

Үндэсний Статистикийн хорооноос Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн албан хаагчдад зориулсан мэдээллийн технологийн сургалт 2019 оны 9 сарын 26,27-ны өдөр зохион байгуулагдсан сургалтанд хэлтсийн мэргэжилтэн А.Амарзаяа хамрагдав.

Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан дагалдан гарсан дүрэм, журмыг танилцуулах, Төрийн албаны зөвлөлөөс “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 09-р сарын 23-ны зохион байгуулсан сургалтанд хэлтсийн төрийн захиргааны албан хаагчдад хамрагдав.

2.4. Нийгмийн бодлогын чиглэлээр:

Нийгмийн даатгалын хэлтэс:

Нийгмийн даатгалын сангийн орлого зарлага: Нийгмийн даатгалын хэлтэс 2019 оны 09 дүээр сарын байдлаар нийгмийн даатгалын санд 29949216,3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж 16578 иргэнд 41934483,0 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгохоор ажиллаж байна. Тэтгэврийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэвэрт нийт 8459 иргэнд 24685819.8 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон. 2019 онд шинээр 506 иргэн тэтгэвэр тогтоолгосны 36 иргэн нь Малчин тэтгэвэр байна. Тэтгэмжийн даатгалын сангаас нийт 4672 даатгуулагчид 1688201,8 мянган төгрөгийн тэтгэмж олгосон. ҮОМШӨ-ний даатгалын сангаас 190 даатгуудагчид 590580,58 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгосон. Ажилгүйдлийн даатгалын сангаас нийт 366 даатгуулагчид 697625,23 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

Нийгмийн даатгалын сангийн авлага:

Сангийн авлага	Мянган төгрөг	
	2018.12.31-ны байдлаар	2019.08.30-ний байдлаар
Нийт шимтгэлийн авлага	1515846,5	1881906,7
Төсөвт байгууллага	35086,9	260165,0
ААН байгууллага	1480759,6	1621742,0

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага:

Үзүүлэлт	2018 8	2019 8	2019 8 2018 8
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	17 588.2	22 966.5	130.6
Тэтгэврийн даатгалын сан	13275.7	17 337.9	130.6
Тэтгэмжийн даатгалын сан	1504.6	1 965.0	130.6
Эрүүл мэндийн даатгалын сан	0	0.0	0.0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	2198.7	2 869.6	130.5

Ажилгүйдлийн даатгалын сан	609.0	793.8	130.3
Нийгмийн даатгалын сангийн зарлага	25 286.8	29 431.6	116.4
Тэтгэврийн даатгалын сан	21428.7	24 789.7	115.7
Тэтгэмжийн даатгалын сан	1686.6	1 930.0	114.4
Эрүүл мэндийн даатгалын сан	0.0	0.0	0.0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1642.9	2 014.1	122.6
Ажилгүйдлийн даатгалын сан	628.4	697.6	111.0

Нийгмийн даатгалд даатгуулагчид, олгосон тэтгэврийн хэмжээ,

Үзүүлэлт	2018 8	2019 8	2019 8 2018 8
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	20 301.0	20 874.0	102.8
Албан журмаар даатгуулагчид	16 578.0	17 062.0	102.9
Аж ахуй нэгж, байгууллага	8 460.0	8 892.0	105.1
Төсөвт байгууллага	8 118.0	8 170.0	100.6
Сайн дураар даатгуулагчид	3 723.0	3 812.0	102.4
2. Тэтгэвэр авагчдын тоо	8 188.0	8 611.0	105.2
Өндөр насны тэтгэвэр	5866	6 205.0	105.8
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1219	1 294.0	106.2
Тэжээгчээ алдсаны	523	504.0	96.4
Цэргийн тэтгэвэр	423	456.0	107.8
ҮОМШӨ*-ний	157	152.0	96.8
3. Олгосон тэтгэвэр	21 971.7	25 263.0	115.0
Өндөр насны тэтгэвэр	15966.5	18 290.6	114.6
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	2477	2 927.8	118.2
Тэжээгчээ алдсаны	1092.2	1 185.2	108.5
Цэргийн тэтгэвэр	1856.0	2 282.2	123.0
ҮОМШӨ*-ний	580	577.2	99.5

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээ 2019 оны 09сарын байдлаар

Үйлчилгээ	Тоо хэмжээ
Шинэ ажлын байрны тоо:	178 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 92-р буурсан.
Ажилд зуучлагдсан иргэдийн тоо:	368 буюу өмнөх оны мөн үеийнхээс 75-аар буурсан.

**Ажлын байрны
захиалгын тоо:**

397 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 142-р буурсан байна.

**Бүртгэлтэй ажил хайгч
иргэдийн тоо:**

588 буюу өмнөх оны мөн үеийнхээс 495-р буурсан.

Зохион байгуулсан нийтлэг арга хэмжээ: БНСУ-ын “Койка” олон улсын байгууллагаас сайн дурын ажилтан тус газар дээр ажиллаж байгаатай холбогдуулан солонгос хэлний сургалтыг зохион байгуулахаар зар мэдээллийг иргэдэд түгээн, суралцах иргэдийг бүртгэн сургалтыг 2019 оны 09 сарын 11-ний өдрөөс эхлүүлсэн бөгөөд 1,3 дахь өдөр 10 иргэн, 2,4 дэх өдөр 32 иргэн нийт 42 иргэнд үнэ төлбөргүй сургалтыг зохион байгуулж байна. 2019 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн үйл ажиллагаатай танилцах хяналт шалгалтыг зохион байгуулж, дэмжлэг авсан иргэдэд заавар зөвлөгөө өгч ажилласан. Хяналт шалгалтад санхүүгийн дэмжлэг авсан 10 иргэн хамрагдсан байна. "Ажилтай орлоготой Монгол хүн" хөтөлбөрийн хүрээнд УБТЗ-ын харъяа Сайншанд сумын ТЗ-ын өртөөнд нийтийн хоол, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, гэрээний хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зөвлөмж өгч ажиллаа.

Төсөл хөтөлбөрийн хүрээнд:

- *Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр:*

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг дахин нийтэд зарлан материалыг хүлээн авч, ажлын хэсгийн хуралд оруулахад бэлэн болгоод байна.

- *Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр:*

"Аж ахуй эрхлэлтийн сургалт"-ыг 18 иргэнд БЕСТ МЕТОД ХХК-ны "Бэст инноваци бизнес хөгжлийг дэмжих төв"-тэй хамтран зохион байгуулсан. Сургалтанд суусан иргэдийг сумдаар харуулбал: Сайншанд, Замын-Үүд сум.

"Старт-ап" 2-р ээлжийн арга хэмжээг 09-р сарын 06-08-ны өдрүүдэд БЕСТ МЕТОД ХХК-ны Бэст инноваци хөгжлийг дэмжих төвтэй хамтран зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг 2019 оны 09-р сарын 08-ны өдөр хийлээ. Сонгон шалгаруулалтанд 15-34 насны залуучуудын 12 бүлэг оролцож, бизнес санаагаа ил тод, нээлттэй танилцуулснаас 6 бүлгийг шалгаруулан 10.0 сая төгрөгийг 36 сарын хугацаатай олгох ЭРХИЙН БИЧИГ гардуулан хурдасгуур арга хэмжээнд хамруулахаар гэрээ байгуулсан.

- *Ажлын байрыг дэмжих хөтөлбөр:*

Аж ахуй эрхлэлтийн сургалтыг “Дарь овооны эзэд” ТББ-ын дэргэдэх сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж нийт 37 иргэнийг хамруулан төсөл бичих, бизнесээ хөгжүүлэх чиглэлээр чадавхижууллаа.

Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээний мэдээлэл, уг арга хэмжээнд хамрагдах бүлгийн төслийг хүлээн авах зар мэдээг нийтэд ил тод зарлан 1 бүлгийн материалыг хүлээн аваад байна.

“Эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг”-ийн 2-р ээлжийн арга хэмжээнд 19 иргэний төслийг хүлээн авч нэгтгээд байна.

- Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

2019 оны 09 сарын 20-нд малжуулах арга хэмжээний 2-р ээлжийн сонгон шалгаруулалтаар 6 сумын 14 өрхийг 68 сая төгрөгөөр малжуулахаар шийдвэрлэснээс 2019 оны 09 сарын 25-29-ны хооронд 3 сумын 7 өрхийг 517 бог малаар малжуулж ажиллалаа.

- Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр:

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сургалтуудыг зохион байгуулж байгаа бөгөөд аймгийн МСҮТ-тэй хамтран тогоочийн сургалтыг ажилгүй, ажилгүйдэлд өртөж болзошгүй 20 иргэнийг хамруулан зохион байгуулж байна.

- Нийтлэг үйлчилгээний хүрээнд:

Ажил хайгч иргэнийг бүртгэх:

Ажил хайгчаар бүртгүүлэх хүсэлттэй иргэний бичиг баримтын бүрдлийг бүрдүүлэн анкетийг бөглүүлэн хүлээн авч ХЗЗ-н LMIS программд бүртгэн, тухайн тайлант хугацаанд идэвхгүй төлөвт шилжсэн иргэдийн бүртгэлийг тухай бүрт нь сэргээн ажилласан.

Ажлын байрны захиалга:

Орон нутагт үйл ажиллагаа эрхлэн явуулж буй ААН, Байгууллагуудтай холбогдож сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг тухай бүрт нь авч 7 хоног бүр өөрчлөн ажилласан мөн сумдаас ирүүлсэн сарын тайлан мэдээнд сул чөлөөтэй ажлын байрны захиалгуудыг нэгтгэн гаргаж мэргэжилтэн бүрт хүргэн мөн телевиз FM болон facebook, пэйж хуудсуудаар зар мэдээг иргэдэд хүргэж ажилласан

Ажилд зуучлах үйлчилгээ:

Сул чөлөөтэй ажлын байрны захиалгын дагуу ажил хайгч иргэдтэй холбогдон мэдээлэл өгч ажилласан. Тайлант хугацаанд 55 иргэнийг ажилд зуучлан ажилласан. Нийт зуучлал аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 368, үүнээс эмэгтэй 159 иргэнийг зуучилсан байна. Шинэ ажлын байр 178 бүртгэгдсэн.

Төсөв, санхүүгийн чиглэлээр: Малжуулах болон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөнд хяналт тавьж ажилласан бөгөөд тайлани сард нийт 9516000 эргэн төлөлт хийгдсэн ба үүнээс малжуулах 2530000 төгрөг /өссөн 103482621 төгрөг/, Санхүүгийн дэмжлэг 6986000 төгрөг /өссөн 60944700 / байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого 9516000 төгрөг, зарлагын 9177000 төгрөгийн гүйлгээг санхүүгийн программд оруулсан.

Нийгмийн халамжийн сангийн талаар: 2019 оны 09 дүгээр сарын тэтгэвэр, тэтгэмж Төрийн банкаар дамжин аймгийн хэмжээнд нийт 8419 иргэнд 1,231.2 сая төгрөгийн санхүүжилт

олгогдсон. Нийгмийн Халамжийн санд 2019 оны 1-9 сарын байдлаар 6917,2 сая төгрөгийн санхүүжилтыг авч, 23425 иргэнд 6331,3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн талаар: Аймгийн хэмжээнд 09 дүгээр сард өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны 37 өргөдөл хүлээн авсан ба эдгээр өрхүүдээр зочилон судалгаа авах ажил хийгдэж байна.

Шинэ төрсөн хүүхдийн эцэг эхийн 168 өргөдлийг хүлээн авч програмд бүртгэн мэдээлэл өглөө.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаар: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комисс 2019 оны 09 дүгээр сарын 06, 25, 26-нд хуралдсаны дагуу хурлаар орсон 109 хүүхдийн хувийн хэрэг, жагсаалтыг праграмд шинэчлэлийг хийсэн.

2019 оны 09 сарын 30-ны байдлаар Дорноговь аймгийн хэмжээнд 232 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас байнгын асаргаатай ХБХүүхэд 222, байнгын асаргаа авдаггүй ХБХүүхэд 10 байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулж Дорноговь аймгийн Ахмадын хороо ахмад настны “Өдрийн үйлчилгээ”-г Сайншанд суманд эхлүүлж нийт 50 ахмад настныг хамруулан асаргаа сувилгааны үйлчилгээг 2019 оны 09 дүгээр сарын 02-ноос 2019 оны 09 дүгээр сарын 27-ний хооронд зохион байгуулав.

Аймгийн хэмжээнд 2391 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас нийгмийн халамжаас 869 иргэн, нийгмийн даатгалаас 1522 иргэний судалгаа мэдээллийг нэгтгэж байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний талаар:

09 дүгээр сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд шинээр 46 өрхийг хамрууллаа. Аймгийн хэмжээнд уг үйлчилгээнд 699 өрх хамрагдаж сард 45,5 сая төгрөгийн эрхийн бичиг олгож байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг иргэдийн сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүдийн СӨБ, ЕБС-д хамрагдалтын судалгааг Сайншанд сумын хэмжээнд гарган аймгийн БСУГ-т сургуульд хамруулах боломжийг судлан шийдвэрлэх талаар албан бичиг хүргүүлээ байна. Аймгийн хэмжээнд уг үйлчилгээ авдаг өрхийн 35 хүүхэд СӨБ, ЕБС-д хамрагдахгүй байна.

Зорилтот өрхийн хөгжил хамгааллын талаар: “Элэг Бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд Монос эм ханган нийлүүлэх байгууллага, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран Сайншанд сумын 2, 3, 4, 6 дугаар багийн Зорилтот өрхийн 19-өөс дээш насны 48 иргэнийг элэгний В,С вирусын эрт илрүүлгийн үзлэг оношлогоонд үнэ төлбөргүй хамруулж, зөвлөгөө өгч ажилласан. Орон нутгийн “DTV” телевизийн Радио нэвтрүүлгийн “Зочны Цаг” нэвтрүүлэгт орж Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрий зорилго, тус хөтөлбөрийн хэрэгжилт цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар иргэдэд мэдээлэл өгсөн.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар:

Салбарын болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, дүрэм, журамд санал өгсөн байдал, хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр :

Тус сард хүүхдийн тусламжийн утсанд 5 дуудлага бүртгэгдсэнийг харьяаллын дагуу Даланжаргалан, Сайншанд, Замын-Үүд сумдад шилжүүлэн хяналт тавьж ажиллаж байна. Тус дуудлагуудыг ангилж үзэхэд гэр бүлийн орчинд хүүхдийн эрх зөрчигдсөн дуудлага 2, боловсролын орчинд эрх нь зөрчигдсэн 2, замын хөдөлгөөнд оролцож байгаад гэмтэл авсан 1 хүүхдийн дуудлага байна.

Гэр бүлийг дэмжих жилийн хүрээнд 9 дүгээр сарын 27-ний өдөр өсвөр үе залуучуудад гэр бүлийн үнэ цэнэ, гэр бүлийн боловсрол, бага насны хүүхдүүдтэй эцэг эхчүүдэд хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар мэдээлэл зөвлөгөө өгөх замаар гэр бүлийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөж буй явдлыг бууруулах зорилгоор 14 сумдын төлөөлөл 120 залуучууд, МСҮТ-ийн төлөөлөл 300 оюутан, Сайншанд сумын 12 цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл 400 эцэг эх нийт 820 хүнд гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтыг Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран зохион байгууллаа.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 3 дугаар хурлыг зохион байгуулж хагас жилийн тайланг гарган хорооны даргад танилцуулан төлөвлөгөөний хэрэгжээгүй ажлыг эрчимжүүлэх, хурлыг сар бүр зохион байгуулж, 10 дугаар сард хүүхдийн хамгааллын аян зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

Хууль зөрчиж Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хяналтад байгаа 8 хүүхдэд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн талаар болон “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын талаарх сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалтаар хүүхдүүд хуульд заасан өөрийн эдлэх эрх, жам ёсоор хүлээх үүрэг, ирээдүйд мэргэжлээ хэрхэн зөв сонгох талаар ойлголтой болсон. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хяналтад байгаа нийт 25 хүүхдийн 10 хүүхдийн бүртгэлийн хавтас баримтыг шинэчлэн бэлэн болгосон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 3 удаагийн хуралд оролцож нийт 109 хүүхдийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас олгогддог мөнгөн тэтгэвэр, тэтгэмжийг 12 сар болон 24 сараар сунгалаа.

Уран жиргээ-2019 уран уншлагын наадамд 14 сум, цэцэрлэг, ЕБС-ийн 4 насны ангилалд 60 гаруй хүүхэд өрсөлдлөө.

Монгол улсын Төрийн шагналт, Ардын жүжигчин, Зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжид түүний хүү монгол Улсын Төрийн соёрхолт, урлагийн гавьяат зүтгэлтэн С.Сүхбаатар нарын дэглэсэн бүжгийн урлагийг хүүхэд багачуудад таниулах, уран бүтээлийн урын санг өвлүүлэх, мартагдсан хуучны бүжгийг сэргээх, түгээн дэлгэрүүлэх, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор өсвөрийн бүжигчдийн улсын XV наадмын 1-р шатны шалгаруулалтыг 09.21-ний өдөр зохион байгууллаа.Тус наадамд

Замын-Үүд, Сайншанд, Айраг сумын ЕБ-ын сургуулийн 250 гаруй өсвөрийн авьяастан оролцлоо. Дорноговь аймгаас улсын уралдаанд гоцлол бүжгийн төрөлд 12, хамтлаг бүжгийн төрөлд 9 хамтлаг оролцох эрх авлаа.

Хүүхдэд ээлтэй орон нутаг санаачилгын хүрээнд ЕБ-ын 5-р сургуулийн 2 ангийн 60 сурагчдаас “Аюулгүй орчны зураглал”-ыг хийлгэж сургуулийн удирдлагуудад танилцууллаа.

Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр сурталчилсан ажлын хүрээнд: Өсвөр үе, залуучуудын мэдлэгийг дээшлүүлж, тэднийг хөгжүүлэх зорилгоор Солонгос хэлний сонирхлын клубийг Койка Олон Улсын сайн дурын ажилтантай хамтран долоо хоног бүрийн даваа, лхагва өдрүүдэд тогтмол хичээллүүлж байна. Сургалтад нийт 36 өсвөр үе, залуучууд хамрагдсан. 09 дүгээр сарын байдлаар байгууллагын үйл ажиллагааны 5 мэдээлэл, 3 шийдвэрийг байгууллагын цахим хаяг, “Өнөөгийн Дорноговь” сонин, орон нутгийн “DTV” телевизээр дамжуулан иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхдийн тусламжийн 108 утасны талаарх нийт 8 шторкийг орон нутгийн “DTV” телевизээр цацуулсан. Аймгийн Засаг даргын 2019 оны А/09 дугаар захирамжийн дагуу 7 хоног бүрийн баасан гаригт байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлж ажиллаж байна. Энэ сард нийт 4 удаагийн мэдээг хүргүүлсэн. Орон нутгийн телевизийн Онцлох мэдээ” нэвтрүүлэгч оролцон хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийн хэрэгжилт, хүүхэд хамгаалагч төслийн талаар мэдээлэл хүргэсэн.

Аж ахуйн нэгж болон иргэдэд шүүд үзүүлдэг төрийн үйлчилгээ: 2 иргэнд хүүхдийн асран хамгаалагч, хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой асуудлаар хууль зүйн зөвлөгөө өгч маргааныг шийдвэрлэсэн. Гэрээсээ дайжсан, сургууль завсардахыг завдсан 2 хүүхдийн эцэг эх, хүүхдүүдтэй уулзаж, сэтгэл зүйн үйлчилгээнд холбон зуучилсан. Насанд хүрээгүй хохирогч 1 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж шүүхийн үйл ажиллагаанд оролцсон холбогдогчид 6 жилийн ялыг шүүхээс оногдуулсан.

Үр дүнд чиглэсэн дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр: Газрын даргын 2019 оны А/08 тушаалын хэрэгжилтийг хангаж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт үнэлгээг хийж холбогдох газарт албан бичгээр болон цахимаар хүргэсэн. Агентлагийн даргын 2019 оны 01/487 албан бичгийн дагуу холбогдох дээд газраас ирүүлсэн хяналт шалгалт, зөвлөмж, албан даалгавар болон тогтоол шийдвэрийн биелэлтийг гаргаж хүргүүлсэн. _Агентлагийн даргын 2019 А/97 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд хийгдсэн хяналт шалгалтын зөвлөмжийн дагуу Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан холбогдох мэргэжилтнүүдэд өгч хяналт тавин ажиллаж байна.

Төсөв, хөрөнгө оруулалт болон Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хүрээнд:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу цахим хуудсаар сар бүр мэдээллээ оруулж ил тод байдлыг хангаж ажилласан. Байгууллагын санхүүгийн мэдээллийн самбарт сар бүр тогтмол цаасан хэлбэрээр жилийн төсөв, 6 дугаар сарын зарцуулалтын эрхийн

хүсэлт, 7 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 2018 оны санхүүгийн тайлан, 2018 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, шилэн дансны мэдээллийг байршуулсан талаар цаасан хэлбэрээр байрлуулсан. мэдээллээ шинэчлэн байршуулж байна. Хяналт шалгалтын дагуу “shilendans.mn” сайтад байгууллагын нэрийг бүтэн оруулж, логоо байрлуулж, бусад мэдээллүүдээ бүрэн бүтэн оруулсан.

Байгууллагын даргын А/70-р тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй хөрөнгийн хагас жилийн тооллогыг 7 сарын 30-ны өдрөөс 8-р дугаар сарын 01-ны хооронд хийж дуусгасан. Тооллогоор дутагдсан хөрөнгө байхгүй, бараа материал дээр байгаа актлах шаардлагатай хөрөнгийг шүүн гаргаж байгууллагын өмч хамгаалах зөвлөлд танилцуулахаар бэлдээд байна.

9 дүгээр сарын байдлаар 52650.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 50735,6 мянган төгрөгийг хүүхдийн хөгжил, хамгааллын зардалд зарцуулаад байна.

10 сард хүүхдийн ордны төлбөрт үйлчилгээний тарифыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахаар санал хүргүүлэхээр болсон.

Бусад ажлын хүрээнд: Аймгийн Засаг даргын 2019 оны А/698 захирамжийн хэрэгжилт “Говийн чоно-2019” олон улсын гамшгаас хамгаалах дадлага, сургуулилтын арга хэмжээ хүүхдийн ордны зааланд 9 дүгээр сарын 16-аас 20-ны хооронд зохион байгуулагдаж, техникийн болон үйлчилгээний чиглэлээр дэмжлэг үзүүлж аймгийн Онцгой байдлын газартай хамтран ажилласан. Замын-Үүд сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын азрын санаачилга, хүсэлтийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”, Цагдаагийн ерөнхий газар, Дорноговь аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хамтран “Хүүхдийн асуудлаарх салбар дундын сургалт зөвлөгөөн” нөлөөллийн арга хэмжээг 2019 оны 09 дүгээр сарын 23-24-ний хооронд зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд байгууллагын удирдлагууд болон 1, 2, 3-р сургуулийн багш ажилчид, эцэг эхийн зөвлөлийн нийт 250 орчим албан хаагчдад хууль эрх зүйн болон хүүхэд, гэр бүлд нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажлын байран дээр чадваржуулах, иргэд, олон нийтэд хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, үүрэг хариуцлагын асуудлаар 7 цагийн мэдээлэл сургалтыг зохион байгуулсан.

Биеийн тамир, спортын газар:

“Монголын Хүүхдийн спортын 6-р их наадам” Улаанбаатар хотод 2019 оны 09 дүгээр сарын 07-оос 15-ны өдрүүдэд спортын 34 төрлөөр, 22 байршилд зохион байгуулагдаж, Дорноговь аймгаас 13 дасгалжуулагч, 147 хүүхэд спортын 16 төрөлд өрсөлдөж, 17 медаль хүртэж /4 алт, 5 мөнгө, 8 хүрэл/, багийн дүнгээр 14-р байр эзэлсэн амжилт үзүүлсэн. Энэхүү арга хэмжээнд оролцоход аймгийн Засаг даргаас 8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

2019 оны 09 дүгээр сарын 27-оос 29-ны өдрүүдэд Үндэсний сурын “Говийн бүсийн чуулга харваа-2019” тэмцээнийг зохион байгуулж Дорноговь, Өмнөговь, Дундговь, Баянхонгор, Өвөрхангай аймгуудын нийт 150 гаруй харваачид багийн харваа, цуваа харваа гэсэн 2 төрөлд өрсөлдөж, багийн дүнгээр Тэргүүн байранд Дорноговь аймгийн үндэсний сурын баг, Дэд байранд Дундговь аймгийн баг, Гутгаар байранд Өмнөговь аймгийн баг, харваачид шалгарлаа.

Боловсрол соёл урлагийн газар:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц: БСШУСЯ-аас ирсэн 6,8-р ангийн 1392 ширхэг 2916020 төгрөгийн үнэ бүхий амьжиргааны түвшин доогуур өрх бүхий айлын хүүхдэд зориулсан зорилтот бүлгийн сурах бичгийг 22 сургуульд хүргүүлсэн. 12 ангийн 8 төрлийн 1416 ширхэг 3656289 төгрөгийн үнэ бүхий эмзэг бүлгийн сурах бичгийг 11 сургуульд түгээлээ. 1951870 төгрөгийн үнэ бүхий 926 ширхэг журналыг ЕБ-ын 22 сургуульд түгээсэн бөгөөд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд ирсэн 330 ширхэг номыг нийт сургуулиудад түгээж тараалт хийсэн.

Боловсролын статистик мэдээ гаргах талаар: 2019-2020 онд сургуулийн өмнөх боловсролд нийт 5520 хүүхэд хамрагдаж, нийт 696 ажилтан байгаагийн 187 үндсэн багш, ерөнхий боловсролын сургуульд 13971 сурагч суралцаж, нийт 1083 хүн ажиллаж байгаагийн 650 нь үндсэн багш байна. Сумдын Засаг дарга нарт мэдээлэх боловсролын салбарын мэдээллийн илтгэлийг бэлтгэн НБХ-т хүргэв. Сургуулийн өмнөх боловсролын сургалт хариуцсан мэргэжилтэн 2019-2020 оны хичээлийн жилийн урьдчилсан тоог сургууль, цэцэрлэгүүдээс авч нэгтгэн дүн шинжилгээ хийж, мэдээлэл хийсэн.

“Говийн чоно” гамшгаас хамгаалах олон улсын дадлага сургуулийн сургалт, сурталчилгааны алба ажиллуулж, мэдээ мэдээлэл, сурталчилгааны ажлыг хариуцан ажилласан төдийгүй ашиглагдах сургалтын проектор техник тоног төхөөрөмжийг бэлтгэж, сургалт, дадлагын үйл ажиллагаанд оролцсон.

“Алтан зул” арга хэмжээг зохион байгуулж, Монголын соёл, урлагийн ажилтны өдөр, Дэлхийн багш нарын өдрийг тохиолдуулан Дорноговь аймгийн боловсрол, соёл урлагийн салбараас шагналд тодорхойлж, БСШУСЯ-ны Боловсролын тэргүүний ажилтан 16, Яамны жуух 52, Соёлын тэргүүний ажилтан 4, “Хөдөлмөрийн тэргүүний ажилтан 2, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Жуух бичиг 4, Монголын багш нарын холбооны шагнал “Багшийн гавьяа”-2, Аймгийн Засаг даргын өргөмжлөл 18, Жуух бичиг 7, Аймгийн ИТХ-ын өргөмжлөл- 2, Жуух бичиг 7, Сайншанд сумын Засаг даргын өргөмжлөл 13, Аймгийн БСУГ-ын Өргөмжлөл 11 байгууллага, хувь хүн, тэргүүний багш, удирдлага 13, Тэргүүний сургууль цэцэрлэг 10, Оны тэргүүний Насан туршийн боловсролын нэгж-1, Дотуур байр-1 тус тус шагнагдсан.

Насан туршийн боловсролын төвөөс дүйцсэн хөтөлбөрөөр 2019 онд насан туршийн боловсролын төвийн нэгжээр хичээллэх хүүхдийн судалгааг гаргуулахаар нийт сумд руу хүргүүлж, судалгааг авч байна. Мөн Боловсрол, соёл урлагийн газраас 3 суманд “Амьдрах ухааны танхим”-ыг байгуулах талаар насан туршийн боловсролын төвийн багш нарт мэдээлэл хүргүүлж ажиллав. Ахмад багш нарын холбооны Зөвлөх үйлчилгээний 5 хүний баг Айраг, Даланжаргалан сумын иргэд, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хайчилбар, нэхмэл, сүлжмэл, оёдол зэрэг сургалтыг зохион байгуулж, 45 хүн хамрагдлаа.

Соёл урлагийн бодлогыг хэрэгжүүлэх талаар: Монголын соёл, урлагийн ажилтны өдөр, Дэлхийн багш нарын өдрийг тохиолдуулан Дорноговь аймгийн боловсрол, соёл урлагийн салбараас шагналд тодорхойлж ирүүлсэн 74 хүний материалыг БСШУС-ын сайдын 2018 оны А/473 дугаар тушаалын дагуу хянан үзэж БСШУСЯ-нд илгээж, 4 ажилтан Соёлын тэргүүний ажилтан болсон.

“Музейн хөгжил” сэдвээр явагдсан Соёл урлагийн ажилтны улсын чуулганд аймгийн төлөөлөл Боловсрол, соёл урлагийн газрын соёл хариуцсан мэргэжилтэн, аймгийн музейн ажилтан, Иххэт сумын Соёлын төвийн музейн ажилтнууд оролцон, туршлагаа солилцон мэргэжил боловсролоо дээшлүүлсэн. Дэлгэрэх суманд болсон “Алтан микрофон” соёл урлагийн ажилтны ур чадварын уралдаанд, Алтанширээ, Иххэт, Айраг сумын соёлын төвийн хамт олон тэргүүлж, бусадтай арга туршлагаа солилцож, ажил ур чадвараа солилцлоо.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Шилийн гол хот, Сөнөд, Авга хошуунд болсон туршлага судлах сургалтад манай аймгийн Номын сангийн болон хөдөөгийн соёлын 35 гаруй номын санчид, ажилтнууд 2019 оны 9 дүгээр сар 16наас 28нд оролцлоо. Монголын соёлын ажилтны “Хөгжлийн эрин” ТББ-аас зохион байгуулсан соёлын төвүүдийн урлагийн анхдугаар наадамд Алтанширээ сумын соёлын төвийн хамт олон шалгаран оролцож БСУГ-аас унааны зардалд 200,0 төгрөгийн дэмжлэг үзүүлсэнээс гадна соёлын төвүүд, Соёлын биет бус өвийн төрлийн шагналд 500,0 төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Иххэт сумын соёлын төвийн номын сан нь монголын анхны мэргэжлийн номын санч Д.Галсанпунцаг агсны 100 жилийн ойг түүний үр хүүхэд, шавь нартай нь хамтран тэмдэглэлэсэн. “Зүүдэнд гэрэлтэх аавын нутаг” соёл олон түмний хөтөлбөрт соёлын зүтгэлтний намтар, түүхэн замнал, баримтат бүтээлийн үзэсгэлэн, дууны бүсийн уралдаан, шатрын болон хүүхдийн хүүхдүүдийг шалгаруулан шагнаж урамшууллаа.

Мэдээ тайлан гаргах талаар: “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын тайлан”, “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан” тус тус 3 жилийн гүйцэтгэлээр гаргасан.

Шинэ Хятад улс байгуулагдсаны 70 жилийн ой, хятад монгол улс дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн баярын хүрээнд Хятад орны тухай танин мэдэхүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, хүүхэд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, зохион бичих сэтгэх чадварыг дэмжихэд чиглэгдсэн “Миний мэдэх Хятад орон” гар зураг, зохион бичлэгийн уралдааныг зохион байгуулан шилдгийг шалгаруулсан. Мөн БНХАУ-ын Эрээн хотын Консулын газраас Анагаахын Шинжлэх ухааны Их сургуульд суралцаж байгаа 15 оюутанд тус бүр 1.0 сая төгрөг, мөн зорилтот өрхийн 68 сурагчдад тэтгэлэг олгосон.

Эрүүл мэндийн газар:

Зорилтот арга хэмжээний хэрэгжилтийн явц:

Эрүүл мэндийн салбарын сул орон тооны мэдээллийг 09 сарын байдлаар авч нэгтгэн www.chd.mohs.mn болон www.dornogobi-emg.mn хаягуудад байршуулсан. 09 сард нийт 13 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг ажлын байраар хангаад байна. Эмнэлгийн хоол эмчилгээ болон цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлчилгээг сайжруулах зорилгоор ЭМГ-ын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 2019 оны 09 сарын 06-ны өдөр Нэгдсэн эмнэлэг, УАУРСТ, Наран өргөө төв хүүхдийн цэцэрлэгийн гал тогооны үйл ажиллагаанд дэмжлэгт хяналтыг зохион байгууллаа.

“Дасгал хөдөлгөөн-Эрүүл мэнд”, Эрүүл амьдралын хэвшил зэрэг сэдвээр 10 байгууллагын 70 орчим хүнд сургалт явуулж, ажлын байрны дасгал заалаа.

2019-2020 хичээлийн жилд төгсөлтийн дараах үндсэн мэргэжилээр суралцах 12 эмчийг батлагдсан хуваарийн дагуу бүртгэлжүүлж, шалгалтанд орох бэлтгэл ажлыг хангаад байна. Долоо хоног бүр DTV телевизээр явуулдаг “Эмчийн зөвөлгөө” буланд 9 удаагийн зөвөлгөө мэдээллийг өгсөн. МСҮТ, 1-р сургууль дээр нөхөн үржихүйн эрүүл мэндийн өртөөчилсэн сургалтыг үе тэнгийн сургагч багш нарын хамт зохион байгуулж, 3 удаагийн сургалтаар 401 хүүхэд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олголоо.

Замын-Үүд суманд үе тэнгийн сургагч багш нарыг шинээр бэлтгэх, тэдний оролцоог идэвхжүүлэх замаар хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор Борхойн наран ӨЭМТ-тэй хамтран “Анхан шатны тусламж үйлчилгээний эрүүл мэндийн үе тэнгийн сургагч багш бэлтгэх”, “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үе тэнгийн сургагч багш бэлтгэх” сургалтыг тус тус зохион байгууллаа. Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 4 сургуулийн 5-6-р ангийн 24 сурагч үе тэнгийн сургагч багшаар бэлтгэгдэн үе тэнгийнхэндээ

амны хөндийн эрүүл ахуй сахих зөвлөгөө өгөх ур чадвараа нэмэгдүүлсэн бол 8-10-р ангийн 19 сурагч хамрагдаж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн “Үе тэнгийн сургагч багш”-аар бэлтгэгдсэн.

Сайншанд сумын ерөнхий боловсролын 2, 3-р сургуулийн сурагчдын дунд анхан шатны тусламж үйлчилгээний эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн өртөөчилсөн сургалтыг үе тэнгийн сургагч багш нарын хамт зохион байгууллаа. Анхан шатны эрүүл мэндийн өртөөчилсөн сургалтыг 6-8 ангийн сурагчдын дунд 4 удаа зохион байгуулж, нийт 381 хүүхдэд амны хөндийн бүтэц, шүд цоорол, түүнээс урьдчилан сэргийлэх, шүдээ зөв угаах зөвлөгөө өглөө. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн өртөөчилсөн сургалтанд 9-11р ангийн 127 сурагч, төмөр замын МСҮТ-ийн 35 оюутан хамрагдаж, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхтэн тогтолцоо, гэр бүл төлөвлөлт, БЗДХ-аас сэргийлэх, бэлгэвч хэрэглэх дараалал, бэлгийн ба хүйсийн чиг баримжаа илэрхийлэл” гэсэн 5 сэдвийн хүрээнд эрүүл мэндийн боловсрол олголоо.

Ерөнхий боловсролын 2, 5-р сургуулийн 4а, 2б ангиудад амны хөндийн эрүүл мэнд сэдвээр сургалт зохион байгуулж, 75 хүүхэд хамрагдлаа. Амны хөндийн кабинетын сургалтанд Сайншанд сумын 1-р цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 55 хүүхэд хамрагдлаа. 7 хоног тумам жирэмсэн эхчүүдэд эрүүл мэндийн сургалт явуулж нийт 38 жирэмсэн эхийг хамруулсан байна.

Говийн чоно-2019” гамшгаас хамгаалах олон улсын дадлага, сургалтын хүрээнд 75 ортой хоёр ээлжээр ажиллах 104 хүний орон тоотой 2-р шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээг дотор, хүүхэд, мэдрэл, сэтгэц, эх барих эмэгтэйчүүд, гэмтэл мэс засал, халдварт, хүлээн авах яаралтай тусламж, оношилгооны чиглэлээр явуулах хүчин чадалтай хээрийн эмнэлэг дэлгэж ажиллав.

Сайншанд сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн 6-8р ангийн сурагчдын дунд АХЭМ-ийн өртөөчилсөн сургалтыг үе тэнгийн сургагч багш нарын хамт 3 ээлжээр зохион байгуулж, нийт 277 хүүхдэд амны хөндийн бүтэц, шүд цоорол, түүнээс урьдчилан сэргийлэх, шүдээ зөв угаах зөвлөгөө өглөө.

Амны хөндийн кабинетын сургалтанд 5-р цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 73 хүүхэд хамрагдаж, шүдэнд халтай, ээлтэй бүтээгдэхүүнийг танилцуулан шүд угаах аргыг зааж өглөө.

ЭМГ-ын даргын 2019 оны 863 дугаар албан бичгээр ЭМБ-уудад өвөлжилтийн бэлтгэл ажлыг шуурхай хангах албан даалгавар хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж, бэлэн байдлын мэдээг нэгтгэхэд 2019 оны 09 сарын байдлаар Айраг, Дэлгэрэх, Иххэт, Сайхандулаан, Мандах, Хөвсгөл, Хатанбулаг, Эрдэнэ сумдын 46 өрхийн 171 хүн отроор өөрийн болон бусад аймгийн нутагт оторлож байна.

Аймгийн ГГХУСАЗСЗ-ийн санхүүжилтээр Сайншанд, Замын-Үүд сумдын Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч мэргэжилтнүүд, Ерөнхий боловсролын сургуулиудын дунд, ахлах ангийн сурагчид, багш нарт, аймгийн ШШГГ, аймгийн ОБГ, аймгийн ХХҮГ-ын ажилтан албан хаагчдад сэтгэцийн тулгамдсан асуудал, хар тамхи, мансууруулаас сэргийлэх чиглэлээр сургалтыг СЭМҮТ-тэй хамтран 2019 оны 09 дүгээр сарын 30-наас 10 дугаар сарын 05-ныг дуустал 6 хоногийн хугацаанд зохион байгуулахаар удирдамж, төлөвлөгөөг гарган байгууллагуудад хүргүүлээд байна.

“Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд Мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төсөлд Мандах сумын эрүүл мэндийн төв 2019 оны 07 сард хамрагдсан. Мандах сумын эмнэлгийн 5 хүний бүрэлдэхүүнтэй баг хөдөөгийн 4 багт явуулын үзлэг хийж, малчдад ЭХО, ЗЦБ, цусны шинжилгээ зэрэг 8 төрлийн шинжилгээ, халдвар болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг хийж, 881 хүн буюу нийт хүн амын 55,2%-г хамруулан, үүнээс шинээр жирэмслэлт-2, цөсний чулуу 6, бөөрний уйланхай-3, элэгний уйланхай үүсгэвэр -4, цөсний ургацаг-3 зэрэг 26 өвчлөл шинээр илрүүлж дээд шатлалд илгээн, 118 өвчлөлийг хяналтандаа авч эмчилгээ зөвлөгөөг өгсөн. Мандах суманд хэрэгжиж буй Мобайл технологийн

төслийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналтыг ЭМГ-ын ажлын хэсэг, ДЭМБ, ЭМЯ-ны ажлын хэсэгтэй хамтран хийсэн. 2019 оны 09 сарын 24-ны байдлаар үзлэг 82,5%тай явагдаж байна. Дэмжлэгт хяналтаар үзлэгт хамрагдсан хүн амын дунд сэтгэл ханамжийн болон эрүүл мэндийн мэдлэг хандлага дадлын судалгааг явуулж, төслийн явцын тайланг ДЭМБ, ЭМЯ-ны ажлын хэсэгт тайлагнасан.

Цаг үеийн ажлын явц:

Томуугийн сайн дурын дархлаажуулалтад нийт 970 хүн хамрагдсан. Эх барих эмэгтэйчүүдийн эмч нарыг чадавхижуулах ажлын байрны сургалт амжилт үргэлжилж хамрагдалт 87 хувьтай. “Эрүүл цус - эрүүл элэг” 2 сарын аяны хүрээнд БЗДХ/ХДХВ/ДОХ-ийн халдварыг илрүүлэх үзлэг, шинжилгээнд нийт 6725 хүн, хепатитын В, С вирусын халдвар илрүүлэх шинжилгээнд 3365 хүн тус тус хамрагдаад байна. ЭМЯ, ЗӨСҮТ, ЭМГ, Замын үүд сумын ЗДТГ-тай хамтран 70 хүний бүрэлдэхүүнтэй “Хил орчмын бүс нутаг дахь тарваган тахал өвчний эрсдэлийг бууруулах” дадлага сургуулилтыг Замын-Үүд суманд зохион байгуулж, цагийн байдлын дагуу тарваган тахал өвчний үеийн хариу арга хэмжээг авч ажиллалаа.

“Орчны эрүүл мэнд”-ийн өдрийг угтсан арга хэмжээний удирдамжийг гаргаж, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлээ. 2019 оны 09 сарын 04-нөөс 10 сарын 04-ний өдрийг хүртэл “Антибиотикийг жорын дагуу хэрэглэе”, “Антибиотикийн даслаас сэргийлье” уриан дор эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх 1 сарын аян зарлаж, удирдамжийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлээд байна.

Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс зохион байгуулж буй “УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ АРГААР ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛЪЯ” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгийг УАУРСТ, Мандах наран эмнэлэг Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг, Шонхор мед эмнэлэгтэй хамтран 2019.09.19-20-ний өдрүүдэд зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр нийт 134 хүнд уламжлалт эмчийн үзлэг, намрын улиралд тохирох хоол ундны онцлогийг харуулсан хоолны үзэсгэлэн, уламжлалт эмийн мэдээлэл, томуугаас сэргийлэх цэгэн бариа зааж, Уламжлалт анагаах ухаанаар эрүүл мэндээ хамгаалах талаар зөвлөгөө өгч гарын авлага тараасан.

Улсын хэмжээнд Сахуу татрангийн эсрэг вакцинаар 7, 15 настай хүүхдүүдийг жилд нэг удаа дархлаажуулалтанд хамруулах ажил явагдаж байна. Дархлаажуулалтанд нийт 1370 хүүхдийг хамруулаад байна.

Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгээр “Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааны хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд 2019 оны 09 сарын 22-ны өдөр Орон нутгийн Төрийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагууд, бусад холбогдох байгууллагуудын дарга нарын нийт 50 хүнийг хамруулсан “БЗДХ/ДОХ/ХДХВ”-ийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл” сэдэвт нөлөөллийн уулзалтыг зохион байгууллаа. Уг уулзалтанд ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ тандалт судалгааны албаны тасгийн эрхлэгч Б.Оюунбэлэг, Б.Жүгдэржав нарыг сургагч багшаар урьж оролцуулан, БЗДХ/ДОХ/ХДХВ-ийн халдвар, вируст гепатитын халдварын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл өгөх сургалт хийж, цаашид БЗДХ/ДОХ/ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх илрүүлэх үзлэг, шинжилгээ, сургалт сурталчилгааны арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулж, хамтран ажиллах талаар санал бодлоо солилцсон үр дүнтэй уулзалт боллоо.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 10.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгээр хэрэгжиж буй “Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааны хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд Сайншанд, Замын-Үүд сумдын зорилтот бүлгийн нийт 1950 хүнийг хамруулж, үзлэгийн явц 97.5 хувьтай байна

Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн яаралтай тусламжийн бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж, хүний нөөц, ор, автомашин шатахуун, эмийн нөөцийн судалгааг шинэчлэв.

IVCO эмийн компаниас 09 сарын 03-ны өдөр “Зүрх судасны өвчний үед ангиотензин рецептор хориглогчийг хэрэглэх нь” сэдэвт 1,5 кредитийн сургалт зохион байгуулж 56 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эм зүйч нар хамрагдлаа.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс -ээс Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт 2015 оны 01 сараас 2019 оны 08 сар хүртэлх хугацаанд төрж, төрөх тасагт эмчилгээ хийгдэж байсан нийт 286 эх, нярайн, хүүхдийн тасагт сүүлийн 5 жилд эмчлэгдсэн 866 хүүхдийн өвчний түүхийг судалж, H-info-3 программд бүртгэгдсэн 2014-2018 оны төрөлт, нярайн өвчлөл, эндэгдлийн архивын материалыг ашиглан дескриптив судалгааны аргаар хүүхдийн тусламж үйлчилгээний судалгааг хийж, 2019 онд бүртгэгдсэн нярайн ховор тохиолдлоор илтгэл бэлтгэн эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эх хүүхдийн тусламж үйлчилгээний олон улсын илтгэлд оролцохоор материалууд хүргүүлээд байна.

“Эрүүл энхийн үйлстэн-2019” эрүүл мэндийн салбарын шилдгүүдийг шалгаруулах арга хэмжээг 2019 оны 09 сарын 28-ны өдөр зохион байгуулж нийт 9 номинацид 64 нэр дэвшигч өрсөлдөж 9 шилдэг эмч эмнэлгийн мэргэжилтэн нар тус бүр 1,0 сая төгрөгөөр шагнууллаа.

2.5. Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр:

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын чиглэлээр:

Алтанширээ сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэгч “PCT” ХХК, Улаанбадрах сумын Соёл спортын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч “Тэгш өргөө” ХХК, Хөвсгөл сумын Соёл спортын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч “Хар хорин өргөө” ХХК, Сайншанд сумын Кино театрын барилгын ажлын гүйцэтгэгч “Энержи парагон” ХХК, Сайншанд сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлын гүйцэтгэгч “Өгөөмөрөн шанд” ХХК, Айраг сумын цэцэрлэгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгч “Хул шанд” ХХК-ийн санхүүжилтийн материалыг тус тус бүрдүүлж, Сангийн яаманд хүргүүлсэн.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр аймагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудын явцын талаар аймгийн Засаг даргын өргөтгөсөн хуралдааны үеэр мэдээлэл бэлтгэж танилцуулсан.

Аймгийн ОНХС-ийн 2019 оны гүйцэтгэл, явцын талаарх мэдээллийг нэгтгэж, аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд өгсөн.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлуудын талаарх мэдээллийг гаргаж, аймгийн Татварын хэлтэст албан бичгээр хүргүүлсэн.

Улсын их хурлын гишүүний 5.0 тэрбум төгрөгийн багцаас 2020 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын саналыг нэгтгэж, УИХ-ын гишүүний туслахд хүргүүлсэн.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд санал авахаар бүх сум болон зарим байгууллага, хэлтсүүдэд албан бичгээр маягыг хүргүүлсэн.

Мандах сумын хүүхдийн цэцэрлэг, Замын-Үүд сумын 2-р цэцэрлэгийн сантехникийн засварын ажлын санхүүжилтийг олгуулахаар материалыг бүрдүүлж, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газарт явуулсан.

Айраг, Хөвсгөл сумдын Соёл спортын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч компаниудад санхүүжилтийг олгосон. Гэрээ сунгуулах хүсэлт ирүүлсэн 5 компанийн гэрээний хугацааг ГХБХБГ-ын дүгнэлтийн дагуу сунгаж, сунгалтын гэрээ байгуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа Айраг сумын Соёл спортын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч

“Элит конкрет” ХХК-д 151.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгуулахаар материалыг бүрдүүлж, Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэж буй Энэрэлт их эрдэнэ, РСТ, Өгөөмөрөн шанд, Миний сайншанд зэрэг компаниудад санхүүжилтийг олгосон. Шинэ хөдөө төслийн хүрээнд мал угаалгын ванн барих ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Сүмбэр өөдөө ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.

Үндэсний хөгжлийн газраас Улаанбаатар хотод зохион байгуулсан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн системийн хэрэглэгчдийн чадавхийг бэхжүүлэх” сэдэвт сургалтанд 2019.09.26-27-ны өдрүүдэд хэлтсийн даргын хамт оролцсон.

Барилга, хот байгуулалт, газрын харилцааны чиглэлээр:

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 бодлогын баримт бичгийн 2019 оны хэрэгжилтийн тайланг гаргасан. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Гаалийн шинэчлэлийн хүрээнд “Хилийн Замын-Үүд боомтын барилга байгууламж, дэд бүтцийн барилга угсралтын ажил” төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх нээлтийн арга хэмжээг Замын-Үүд суманд 2019.09.12-ны өдөр зохион байгуулсан. Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх хүсэлтийг хүлээн авч судлан 11 иргэн, ААНБ-д барилгын ажлын зөвшөөрөл олгосон. Аймгийн ГХБХБГ-ын дэргэдэх Барилгын материалын лабораторит 187 дээж сорьцыг хүлээн авч 165 барилгын материалд сорилт шинжилгээ хийсэн байна. Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх ашиглуулах чиглэлээр аймгийн Засаг даргын 5 захирамж шийдвэр гарсан. Газар эзэмшүүлэх ашиглуулах гэрээг 1305 иргэн, ААНБ-тай шинээр болон шинэчилэн байгуулж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 114 иргэн, ААНБ-ын газар эрхийг хүчингүй болгосон байна. Газрын төлбөрийн орлого 38,7 сая мянган төгрөг, өссөн дүнгээр 624 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэв. Гамшгаас хамгаалах “Говийн чоно олон улсын дадлага сургалт”-ын хүрээнд мэргэжлийн анги салбарт ашиглах 33 хэсгийн газрын зургийн эхийг бэлтгэж ААНБ-д хүргүүлсэн. Хилийн цэсийн маргаан бүхий сумдын судалгаа, тайлбарыг нэгтгэж ГЗБГЗЗГ-т хүргүүллээ.

Байгаль орчны чиглэлээр: Айраг, Даланжаргалан сумдын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 2 тусгай зөвшөөрлийг сум болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын саналыг үндэслэн шинээр олгосон. Хатанбулаг, Улаанбадрах, Хөвсгөл сумдын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 4 өргөдөлд санал авахаар холбогдох сумдад албан бичиг хүргүүлж, 4 талбайд олгох боломжгүй гэсэн шийдвэрийг мэдэгдэж өргөдлийг хаасан. Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө, МУ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 бодлогын баримт бичиг, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг тус тус гаргаж холбогдох хэлтэст өгсөн.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сурталчлах, салбарын асуудлын бодлого, үйл ажиллагааг мэдээллэж сурталчлах зорилгоор манай хэлтсийн харьяа байгууллагууд 2019 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр Сайншанд сумын Гэр бүлийн талбайд “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ”-ийг зохион байгуулсан. Өдөрлөгт төрийн 5 байгууллага, төрийн өмчит 3 байгууллага, Ногоон зээл олгогч Хаан банк, Төрийн банк, Капетрон банкууд, Эко ариун цэврийн байгууламж үйлдвэрлэгч, Шахмал түлш үйлдвэрлэгч, Түлшний хэмнэлттэй зуух үйлдвэрлэгч нийт 14 аж ахуйн нэгж байгууллага оролцож иргэдэд мэдээлэл өгч, шуурхай үйлчилгээ үзүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Биеийн тамир спортын газар хамтран эрүүл, цэвэр агаарт, эрч хүчтэй нэг өдрийг өнгөрүүлэх уриатай аймгийн аварга баг шалгаруулах “Үүргэвчтэй явган аялал”-ыг 09 сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Энэ жилийн явган аялалд 12 багийн гаруй 60 гаруй тамирчид оролцож Тэргүүн байранд аймгийн Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх алба, дэд байранд АвтоТээврийн төв, Гутгаар байранд Цагдаагийн газар, тусгай байранд Онцгой Байдлын газар тус тус шалгарч, шилдэг эмэгтэй аялагчаар Цагдаагийн газрын ажилтан н.Энхсоёл, шилдэг эрэгтэй аялагчаар мөн Цагдаагийн газрын ажилтан н.Мөнхбат нар тодорсон.

Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг 2019.09.13-14-ний өдрүүдэд Сайншанд суманд зохион байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.

Мал аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний талаар гарсан Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 285 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх, өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх чиглэлийг сумдын Засаг дарга нарт өгсөн. Аймгийн нөөцөд өвс, тэжээл авах ажлын хэсгийг байгуулсан. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой шийдвэр гаргуулсан. “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг 13,14-ний өдрүүдэд Сайншанд суманд 16 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд нийт 104 иргэн, аж ахуйн нэгж хүнс, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүнээр оролцож 68.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Иргэн бүр санаачлагч-Өрх бүр үйлдвэрлэгч” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэн гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулсан. Одоогоор 120 гаруй өрхийн үйлдвэрлэл эрхлэгч гэрчилгээг гардан аваад байна.

Айраг, Алтанширээ, Иххэт, Даланжаргалан, Дэлгэрэх, Өргөн, Эрдэнэ, Сайншанд сумдад газар тариалан, ЖДҮ-ийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг зохион байгуулсан.

Даланжаргалан, Иххэт, Өргөн, Улаанбадрах, Сайхандулаан сумдын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэнүүд манай хэлтэст сэлгэн ажилласан. Тус мэргэжилтэнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, ажлын дадлага туршлага, ажиллах арга барилд сургах, харилцан туршлага судлуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Зам, тээвэр, эрчим хүч, харилцаа холбооны чиглэлээр:

Алтанширээ сумын халаалтын зуух, инженерийн шугам сүлжээг цахилгаан эрчим хүчээр хангах зориулалтаар ашиглах 160 ква чадалтай 35/0,4 кВ-ын дэд станцыг Иххэт сумын Баян багаас Алтанширээ суманд шилжүүлэх, Алтанширээ сумын хөрөнгөд бүртгэх тухай аймгийн Засаг даргын 2019 оны А/710-р захирамжийг батлуулан холбогдох сум, агентлагт чиглэл хүргүүлж ажилласан. “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр ашиглалтад хүлээн авах ёслолын арга хэмжээг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2019 оны 09-р сарын 04-ний өдрийн А/701 захирамжаар батлуулсан.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын “Хөх дэл” уурхайгаас Хэнтий аймгийн Бор-өндөр чиглэлд тээвэрлэлт явуулах чиглэлийг баталсан аймгийн Засаг даргын 2018 оны 02-р сарын 12-ны өдрийн А/164-р захирамжийг 2019 оны 09-р сарын 04-ний өдрийн А/702-р захирамжаар хүчингүй болсож, Монголросцветмент ТӨҮГ-т мэдэгдэл хүргүүлсэн. Эрдэнэ суманд байрлах Хилийн цэргийн 0129-р ангийн “Шанага”-ын заставаас “Ар булаг”-ийн застав хүртэл ЦДАШ барьж цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг УБТЗ НХХ-ийн харьяа Эрчим хүч, ус хангамжийн Чойр хэсэгт солигдож буй модон тулгууруудыг шилжүүлэн ашиглах замаар шийдвэрлэх хүсэлтийг УБТЗ НХХ-т хүргүүлсэн. Сайншанд-Замын-Үүд чиглэлийн улсын чанартай авто замаас Өргөн сум хүртэлх 18,25 км авто замын зураг төсвийн шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах газрын асуудал шийдвэрлэсэн захирамж гаргаж зургийн компанид хүргүүлсэн.

Иххэт, Өргөн, Айраг сумд болон Зүүнбаян багт бохир ус шингээх байгууламж зураг төсөв боловсруулах ажлыг Алтайн газрын хүч ХХК гүйцэтгэж байна. Уг ажлыг гүйцэтгүүлэхэд шаардлагатай газрын асуудлыг холбогдох сумдад чиглэл өгч шийдвэрлүүлсэн.

Алтанширээ суманд халаалтын зуух, нэгдсэн инженерийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгүүлж 2019 онд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байгаатай холбогдуулан зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох компани байгууллагын төлөөллийг хамруулсан хурлыг зохион байгуулж, аймгийн засаг даргаар шийдвэрлүүлж ажилласан.

Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт уул, уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх авто замын чиглэл батлуулах хүсэлт ирүүлсэн 3 компанийн хүсэлтийн дагуу 2019.09.12-ны өдөр Даланжаргалан суманд ажилласан.

Аймгийн төвийн дулаан хангамжийн системд 2019 онд хийхээр төлөвлөсөн ажлуудын гүйцэтгэлийн мэдээллийг УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ ТӨХК-д гаргаж өгсөн.

Орон нутгийн замын сангий орлогыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэг, оношлогоонд хамрагдсан эсэхэд хяналт шалгалт зохион байгуулах удирдамжийг баталсан. Хяналт, шалгалтын ажил 2019.09.30-ны өдрөөс 2019.10.25-ны өдрийг хүртэл 25 хоногийн хугацаатай зохион байгуулагдана.

Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Айраг эксплорэйшн” ХХК-ийн МУ-019106 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Майхант-1” уурхайгаас “Эко хэлхээ” ХХК-ийн баяжуулах үйлдвэр хүртэлх 38 км орон нутгийн чанартай авто замын чиглэлийг баталсан.

ЗТХЯ-наас зохион байгуулсан “Авто замын засвар арчлалт болон үндсэн хөрөнгийн менежментийн талаар бодлогын зөвлөгөө өгөх, чадавхийг бэхжүүлэх” сургалтад салбарын мэргэжилтэн хамрагдсан.

2.6. Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын чиглэлээр:

Засгийн газрын тогтоол 8, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 1, аймгийн ИТХ-ын тогтоолыг хяналтад аван ажиллаж байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэмэлт өөрчлөлтийг цахим үнэлгээний системд оруулж хэлтэс, нэгж, мэргэжилтнүүдэд хувиарласан.

Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хийгдэх төлөвлөгөөний хэлтэст хамаарах заалтын 3 дугаар улирлын тайланг гарган, ТЗУХ-т хүргүүлсэн.

Аймгийн дэд хөтөлбөрүүдийн 23 төлөвлөгөөг холбогдох хэлтсүүдээс авч, “Ухаалаг Засаглал” ТББ-ын ажилтанд хүргүүлж, dornogovi.unelgee.gov.mn системд оруулах бэлтгэл ажлыг хийсэн.

Оны сүүлийн хагас жилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бодлогын баримт бичгүүдийг тайлагнах хуваарийг боловсруулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, хэлтэс, агентлаг, байгууллагуудад хүргүүлсэн.

Аймгийн 2018 оны үйл ажиллагаанд ЗГХЭГ-ийн ХШҮДАГ-аас хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулж, хэлтсүүдэд хүргүүлсэн.

“Төв, суурин газрын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 270 дугаар тогтоолын хэрэгжилтийг 3 дугаар улирлын байдлаар нэгтгэн, ЗГХЭГ-т хүргүүлсэн.

АЗДТГ-ын хэлтэс, нэгж, албан хаагчдын үйл ажиллагаанд дотоод аудит хийх удирдамжийн төслийг боловсруулав.

Аймгийн Засаг даргын 2016-2019 оны захирамжуудаас байнгын шинж чанартай захирамжуудыг түүж, хяналтад авах ажил гүйцэтгэсэн. Байнгын шинж чанартай хэрэгжиж байгаа захирамжуудыг нэгдсэн жагсаалтад бүртгэж, захирамжуудын скайнердсан хуулбарыг файлаар татаж бэлтгэсэн.

Аймаг хөгжүүлэх хэтийн зорилтын бодлогын баримт бичиг “Дорноговь аймгийн мастер төлөвлөгөө 2011-2021” –ийн 2017 оны нэгдсэн тайланг хянаж III үе шатны хэрэгжилтийн тайланг гаргах хүснэгтийг бэлтгэн хэлтсүүдэд хүргүүлсэн.

Засаг даргын өргөтгөсөн хуралд ирсэн сумд, агентлагийн дарга нарт бодлогын баримт бичгийн оны эхний хагас жилийн хэрэгжилт, эрчимжүүлэх шаардлагатай ажил

арга хэмжээний мэдээллийг өгсөн. Хэлтсийн албан хаагч нарын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс авах санал асуулгын төслийг боловсруулсан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын бичиг баримтын 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланд гарсан алдаа дутагдал, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл бэлтгэн, Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад сургалт, мэдээлэл хийсэн. Аймгийн ЗДТГ-т туршлага судлах, сэлгэн ажиллахаар ирсэн зарим сумдын Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн мэргэжилтэн, Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, Нийгмийн бодлогын мэргэжилтэн нарт зориулан ажлын төлөвлөгөө гарган, “Тайлан мэдээнд гардаг нийтлэг алдаа”, “Цахим сан” “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай ойлголт”, “Төлөвлөлт хийх арга зүй” сэдвээр сургалт хийн, хяналт-шинжилгээ, үнэлгээний бодлогын баримт бичгийн хяналт, хэрэгжилт, тайлагналтын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дадлага хийлгэсэн. Аймгийн Цагдаагийн газрын тасгийн дарга нар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Онцгой байдлын газрын холбогдох албан хаагчдад байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах болон хяналт-шинжилгээ, үнэлгээ, цахим сангийн талаар сургалт зохион байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” сургалтад хэлтсийн бүрэлдэхүүн хамрагдсан. Аймгийн ЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн хэмжээний 122 төрийн байгууллагын цахим хуудас ашиглалтад хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн. Аймгийн ЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсүүдийн бодлогын баримтын хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ хийсэн. МУ-ын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийг тайланг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн Засаг даргын 2019.09.25-ны өдрийн 1/1668 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР